



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 1/538

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай" 259 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (Covid-19) цар тахлаар өвчилсөн иргэдийг халдварт улаан бүсэд 14 хоногийн хугацаанд эмчилэн ажилласан эмнэлгийн эмч, сувилагч, ажилчдыг тусгаарлан ажиглах "Шунхлай" зочид буудал, "Харшийн гэгээ" ХХК байранд байрлуулсаны зардал, Шуурхай штабын мэдээ тайланг нэгтгэдэг зөөврийн компьютерийн hard 128 GB сольсон зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардал болох 8,870,000 (найман сая найман зуун далан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

011101140

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны...<sup>11</sup>  
дугаар сарын ...-ны өдрийн...<sup>15.38</sup>  
дугаар захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	"Шунхлай" Зочид буудал	хоног	92	50,000	4,600,000
2	"Харшийн гэгээ" ХХК	хоног	83	50,000	4,150,000
3	"Өвөрхангайн цахим сүлжээ" ХХК	ширхэг	1	120,000	120,000
НИЙТ ДҮН					8,870,000

Нийт –8,870,000.00

-оОо-